

МОНГОЛ, ХЯТАД, ОРОС ГУРВАН УЛСЫН II ФОРУМЫН ТУХАЙД

Монгол, Хятад, Орос гурван улсын анхдугаар форумыг Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал доктор, профессор Л.Хайсандай санаачилж, улмаар Монгол Улсын ерөнхий сайдын ивээл дор БСШУЯ, ГХЯ, ШУА-тай хамтран Олон улс судлалын хүрээлэн “Монгол, Орос, Хятад: XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний форумыг 2008 оны 6 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан билээ.

Монгол, Хятад, Орос гурван улсын II форумыг БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн Ази-Номхон далайн бүс нутгийн хүрээлэн зохион байгуулах үүрэг хүлээсний дагуу 2009 оны 6 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд Бээжин хотноо “Хятад, Монгол, Орос: энх тайван, хөгжил, хамтын ажиллагаа” сэдвийн дор амжилттай явуулав. Форумд БНХАУ-аас Хятадын Нийгмийн шинжлэх ухааны академийн Ази-Номхон далайн бүс нутгийн хүрээлэнгийн захирал Жан Юйянь тэргүүтэй эрдэмтэд, мөн ӨМӨЗО, ШУӨЗО-ы эрдэмтэд, ОХУ-аас Оросын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн академич В.С.Мясников тэргүүтэй эрдэмтэд, Москвагийн Олон улсын харилцааны сургуулийн Дорнод Азийн Төвийн болон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын захирал А.Лукин, ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн Монгол, Солонгосын тасгийн эрхлэгч А.Воронцов, Өвөр байгалийн Хүмүүнлэг-багшийн их сургуулийн дэд захирал В.Кузнецов, Өвөр байгалийн Хүмүүнлэг-багшийн их сургуулийн Олон улсын хөрөнгө оруулалтын судалгааны төвийн захирал Г.Васильев, ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн Монгол, Солонгосын тасгийн эрдэм шинжилгээний ажилтан В.Мешанинов нар, Монгол Улсаас ШУА-ийн ОУСХ-ийн захирал, доктор, профессор Л.Хайсандай, Стратегийн судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор Р.Батмэнд, ОУСХ-ийн эрдэмтэн доктор Н.Ариунгуа, доктор Н.Төмөр, доктор Ч.Батцэцэг, доктор К.Дэмбэрэл, доктор А.Нямдолжин нарын нийт 40 хүн оролцож сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Энэ удаагийн форум Монгол-Хятадын харилцааны 60 жил, Хятад-Оросын харилцааны 60 жилийн ойтой давхцаж буйгаараа онцлогтой байсан юм. Форумд БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Ли Шэньмин оролцож баяр хүргэж, форумын үйл ажиллагаанд амжилт хүсэв.

Форумын үйл ажиллагаа: 1. Хятад-Монгол-Оросын харилцаа 60 жил. 2. Олон улсын санхүүгийн хямрал ба Хятад-Монгол-Оросын хамтын ажиллагаа. 3. Зүүн Хойд Азийн аюулгүй байдал, дипломат харилцаа ба Хятад, Монгол, Оросын хамтын ажиллагаа гэсэн үндсэн 3 хэсэгт хуваагдаж эрдэмтэд илтгэлээ хэлэлцүүлэв. Хурлыг илтгэгч илтгэлээ тавьсны дараа түүнийг албан ёсны шүүмлэгч нэгбүрчлэн шүүмжлэхээс гадна нийт хуралдагсдын өргөн хэлэлцүүлэг явуулж, санал сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлэх боломжтойгоор зохион байгуулжээ.

Форумд оролцсон 3 улсын эрдэмтэн судлаачид Хятад, Монгол, Оросын харилцааны 60 жилийн түүх, алдаа оноо, амжилт, бүх талын хамтын ажиллагааны үр өгөөж, хэтийн төлвийн талаар санал бодлоо солилцсон юм.

Нөгөөтэйгүүр олон улсын санхүүгийн хямралын өнөө үед Монгол, Орос, Хятад 3 улс хямралыг хэрхэн даван туулах, тулгамдаж буй асуудлыг гэтлэн давах арга хэлбэрийг эрэлхийлэх, ялангуяа худалдаа, эдийн засаг, уул уурхай, дэд бүтэц, эдийн засгийн чөлөөт бүс, байгаль экологийн асуудал, бүс нутгийн аюулгүй байдал маш чухлаар тавигдаж, ийм нөхцөлд бүх талын хамтын ажиллагааг стратегийн хөгжилтэй уялдуулах, харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх тухайд эрдэмтэд үзэл бодлоо уралдууллаа.

II Форумд оролцсон 3 улсын эрдэмтдийн тавьсан илтгэл тэдгээр улсын хоёр талт болон гурван талт харилцааг цаашид гүнзгийрүүлэн судлахад асар их ач холбогдолтой боллоо хэмээн дүгнэв. Дараагийн III Форумыг ОХУ-д хийхээр товлон, II Форумыг амжилттай сайн зохион байгуулсан БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн Ази-Номхон далайн бүс нутгийн хүрээлэнд талархснаа илэрхийлье.